



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг  
томилох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”, 85 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 05/17144 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүдээр С.Нямбаяр (Засгийн газрын референт), Ж.Дэлгэржаргал (Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга), Ц.Шинэхүү (Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга), Б.Янжинлхам (Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн), хараат бус гишүүдээр Г.Лхамдулам, Д.Ган-Эрдэнэ нарыг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс томилсугай.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ